



2013.03.14

Д.Нацагдорж

Хуучин хүү<sup>1</sup>

Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн байдал ороо бусгаа. Элстэй шанд, буттай цайдмыг дагаж, хааяа нэг хар гэрээс утас суунаглана. Дөрвөн зүг цэв цэлийн уйтгартай, цагаан униар тунана. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна. Айлын хаяагаар үхрийн баас үргэлжилжээ. Үүгээр түүгээр хэдэн тугал оодогнон давхина. Хөлд орохос аваад, үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнз.

Гавж Жамбал хоймор сууж, бурхан ном хэмээн буруу зөв чалчих ба зайсан Намжил гаднаас ирж, хууль ёс хэмээн худал үнэн ярихыг сонсоор, өдөр сарыг улируулна. Тэртээ уулыг өнгөрвөл айлгүй хэмээн бодож, тэнгэрийн хаяанаас цааш газаргүй хэмээн сэтгэсээр, түмэн хэргээс хоцорч, дэлхийн боловсролоос гээгдэнэ. Өглөө бурханд залбирч, үдэш тэнгэрт мөргөсөөр нэг нас харанхуй мананы дотор барна.

Хуучин хүү хул морин дээрээ хөндлөн сууж, хатишуулсаар хүрч ирэв. Цагаан даавуу алчуураар толгойгоо ороожээ. Ширэлдсэн хар гээгийн сэrvийсэн хэдэн үс шанаа уруу нь унжина. Урагдаж навтарсан хар ханцуйг сугалдаргалж, хиртэж сайртсан бор тохой гаргажээ. Тавхийтэл мориноосоо буун, тасхийтэл жолоогоо сойгоод, тоосонд дарагдсан урд хормойгоороо наранд шарагдсан нүүрийнхээ хөлсийг арчиж, нусаа хүрхийтэл нийгээд, гэрт оров. “Балдангийнх эсгийгээ хийж байна. Цэндийнх хонио хужирлаж байна. Дамба морь эрэхээр явсан. Гомбо хангай ороод ирсэн.” гэх зэрэг хэв ерийн хэдэн үгийг ах зах хүмүүстээ сонин болгон ярьж, гавж гуай хэмээн доогуур харан, зайсан гуай хэмээн дорий дуугарсаар, зуухны хажууд сууна. Авгай хүүхдээс аяга тараг, хэсэг хусам олж идээд, тэндээс гарч, баян Балжирынд унага татаж өгч, айраг олж уун, нэг үдийг өнгөрүүлиэ. Дэндэв тайжийнд хонь гаргаж өгч, гэдэс олж идэн, нэг үдшийг дуусгана. Хэдийгээр ухаан сэргэлэн боловч, зүүн хошууны захад хүрсэнгүй, баруун мөрний тэртээ гарсангүй, зөвхөн гурав, дөрвөн өртөө эргэн тойрон газрын дотор оршин суусан тул, юуг үзэж мэдэж, юуг сонсох ажээ.

Нас хэдийгээр залуу боловч, үгээгүй ядуу, өнчин балчир тул, нутаг сумын хэдэн айлд ээлжлэн зарагдсаар, олигтой аж амьдралын замыг нэгэнт алджээ.

<sup>1</sup>Д.Нацагдорж “Зохиолууд” Улаанбаатар, 1961 он, 208-209-р тал.

Өвлийн хүйтнийг адуу манаж өнгөрүүлэн, зуны халууныг хонь хариулж гэтэлгэх багаад намар ичиж, хавар гарагч тарваганаас зовлонтойгоор он жилийг нөхцүүлнэ. Өтгөс, хуучид энэ хоёрын үгиэс бус үнэн юмгүй, өвөлжөө, зуслан, хаваржaa, намаржaa энэ дөрвөөс өөр явах газаргүй хэмэн санаж, хөмөрсөн тогооны доторхтой адил хөдөөгийн бүдүүлэг байдалд хүмүүжнэ. Юутай гомдолтой зэрлэг амьдрал, юутай хайлалтай залуу нас, юунд шинэ өртөнцийг үзэхийг үл хүснэ? Хүмүүжил нь энэ гунихралтай байдлыг хуучин хүү өөрөө бас яахин мэнэ. Хуучны феодал ба лам нарын гайг мөн хэрхэн танина. Дэмий л байдалд автагдаж, зовлон нь жаргал, зэрлэг нь цэнгэл болоод, нэг аймаг улс цөм хуучин хүүгийн адил нүдээ аньж, чихээ бөглөн, өртөнц гэгч чухам юу болохыг үзэлгүй, мэдэлгүй хөндий талд хоосоор хоцроход тулжээ.

**Хайран хайран, хөөрхий хөөрхий.**

Гэтэл хуучин хүүгийн нэг нөхөр нь хувьсгалын бууг тавьсан өдрөөс эхлэн, хөмөрсөн тогооны дотор гэрэл тусч, нэгэн аймаг улс сээрэв. Тэнгэрийн хаяанаас цааш газар байдгийг мэдэж, таван далай таван тивийг танин, шинэ өртөнц дээр хамт явах замыг нээв.

**Хөх монгол улаан монгол болов.**

**Хуучин хүү шинэ хүү болов.**

**Юутай завшаан, юутай баяр.**

*1930 он.*